



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2015 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 01/38

Мөрөн

Төсвийн хэрэгжилтийг хангах зарим  
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.1-ийн “е” заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6,4,8, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалт, Монгол улсын засгийн газрын 2015 оны 109 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн төсвийн орлого 1-р улирлын байдлаар 694,0 сая төгрөгөөр тасарч төсвийн эх үүсвэр дутагдалтай байгаад анхаарч дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахыг Татварын хэлтсийн дарга В.Баяраад үүрэг болгосугай.

1.1. Хуримтлагдсан татварын өр, дутуу төлөлтийг хууль тогтоомжийн дагуу бүрэн барагдуулах арга хэмжээ авах

1.2. Төсвийн орлогыг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжилтийг зохион байгуулан гүйцэтгэлийг сар бүр Засаг даргад мэдээлэх.

2. Төсвийн орлогыг бүрдүүлэх өмнө жилийн татварын өр төлбөрийг барагдуулах чиглэлээр Татварын хэлтэстэй хамтран ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Р.Жаргалсайхан/, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга /Г.Цэнд-Аюуш /, Авто тээврийн төвийн дарга /З.Дарьсүрэн/, Мөрөн сумын Засаг дарга /Ц.Гансүх/ болон бусад бүх сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах талаар доорх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахыг бүх шатны төсөв захирагч нарт даалгасугай.

3.1 Төсвийн орлогыг бүрдүүлэх, нөөцийг дайчлах ажлыг зохион байгуулах

3.2 Төсвийн орлогын эх үүсвэртэй уялдуулан төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж зардал хэмнэх боломжийг дайчлан өр үүсгэхгүй ажиллах


3.3 Өмнө жилүүдэд үүссэн авлагыг бүрэн барагдуулах ажлыг зохион байгуулах

3.4 Төсвийн талаар гарсан хууль тогтоомжууд болон Монгол улсын Засгийн газрын 2014 оны 147-р тогтоолын холбогдох заалтуудыг бүрэн хэрэгжүүлж урсгал зардлыг хэмнэх, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг байгууллага бүр гаргаж гүйцэтгэлийг тооцон тайлагнах

4. Нэгдүгээр улирлын байдлаар боловсрол, соёлын салбар 506,8 сая төгрөгийн өртэй гарсан байдалд дүгнэлт хийж өр үүссэн шалтгаан нөхцөл, жилийн төсөв хүрэлцэх эсэх талаар судалгаа шинжилгээ хийж холбогдох яамдад санал хүргүүлж ажиллахыг Боловсрол Соёлын газрын дарга /Н.Баатар-Очир/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/ нарт үүрэг болгосугай

5. 2015 онд шинээр улс орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлхээр тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төсвийн эх үүсвэртэй уялдуулан зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Худалдан авах ажиллагааны алба /Б.Болд/, Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга /Х.Ган-Очир / нарт үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/, төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий санхүүч /Ц.Мөнхтуяа/ нарт хариуцуулсугай.

ДАРГА  А.ЭРДЭНЭБААТАР

